



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 01 өдөр

Дугаар А/287.

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын
ажлын албаны бүрэлдэхүүнийг шинэчлэн
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.25 хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 дугаар сарын сарын 23-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/400 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын гурав дахь хэсэг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрлийн зохицуулалтын ажлын албаны бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.
2. Ажлын албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллахыг Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга (Л.Зэндмаа)-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/287 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны
дугаар сарын-ны өдрийн дугаар
тушаалын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	ЭЭХХЗГ-ын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	ЭЭХХЗГ-ын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн ЭЭХХЗГ-ын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын эмнэлгийн хэрэгсэл, оношлуур үйлдвэрлэх, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	ЭЭХХЗГ-ын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн ЭЭХХЗГ-ын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын Эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн экспорт, импортын лицензийн асуудал хариуцсан мэргэжилтэн ЭЭХХЗГ-ын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын Эмийн импортын лицензийн асуудал хариуцсан мэргэжилтэн ЭЭХХЗГ-ын Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газрын Эмийн экспортын лицензийн асуудал хариуцсан мэргэжилтэн ЭЭХХЗГ-ын Эмийн бүртгэлийн хэлтсийн Эмийн бүртгэлийн зохицуулалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн ЭЭХХЗГ-ын Эмийн бүртгэлийн хэлтсийн бүртгэл мэдээний сангийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн ЭЭХХЗГ-ын Эмийн бүртгэлийн хэлтсийн оношлуурын бүртгэл, сунгалт, өөрчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

ЭЭХХЗГ-ын Эмийн бүртгэлийн хэлтсийн биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, сунгалт, өөрчлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

ЭЭХХЗГ-ын Эмийн бүртгэлийн хэлтсийн эмийн сунгалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

ЭЭХХЗГ-ын Эмийн бүртгэлийн хэлтсийн импортын эмийн бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

ЭЭХХЗГ-ын Эмийн бүртгэлийн хэлтсийн эмийн бүртгэлийн өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн

ЭЭХХЗГ-ын Эмийн бүртгэлийн хэлтсийн үндэсний үйлдвэрийн эм, уламжлалт эмийн бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн

ЭЭХХЗГ-ын Эм үйлдвэрлэлийн хэлтсийн Эмийн үйлдвэрийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

ЭЭХХЗГ-ын Эм үйлдвэрлэлийн хэлтсийн Шинэ эм, инновацын асуудал хариуцсан мэргэжилтэн

ЭЭХХЗГ-ын Эм үйлдвэрлэлийн хэлтсийн Биологийн идэвхт бүтээгдэхүүн, протез, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн